



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 6/37

Ховд

Б.Даваадоржийг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр ажил, албан тушаалд шижүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Бямбадоржийн Даваадоржийн ирүүлсэн хүсэлтийн дагуу 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөр тасалбар болгон Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүрэгт ажлаас чөлөөлж Сум дундын ойн ангийн даргаар шилжүүлсүгэй.

2. Б.Даваадоржийн ажлыг хүлээлцүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Б.Даваадоржтой холбогдох тооцоог хийж дуусгахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн нягтлан бодогч (Б.Энхмандал)-д даалгасугай.

4. Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргыг шинээр томилогдох хүртэлх хугацаанд хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэхийг тус хэлтсийн ахлах мэргэжилтэн (С.Дорж)-д үүрэг болгосугай.


ДАРГА



Б.САНДАГСҮРЭН

8400003 0227  
Tush B/37 Kh

Засаг даргын Тамгын газрын даргын  
2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн  
Б/37 дугаар тушаалын хавсралт



### АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АЖЛЫН ХЭСЭГ

- Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганболд (Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирлагын хэлтсийн дарга)
- Гишүүд:
- Б.Энхмандал (Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн нягтлан)
  - Х.Болормаа (Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн нярав)
  - Б.Даваажаргал (Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
- Нарийн бичиг: Х.Мөнхзаяа (Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

-оОо-